

**АМЬТАН, УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ
УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ҮЕИЙН ХОРИО ЦЭЭРИЙН
ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

Хуулийн нэр	Хуулийн зорилго	Худалдаатай холбоотой заалтууд
Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай	1.1. Энэ хуулийн зорилт нь амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үед мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалт хийхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.	4дүгээр зүйл. Хорио цээрийн хяналт, шалгалтад хамаарах зүйл 4.1. Энэ хуулийн хүрээнд дор дурдсан амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналт, шалгалтад хамруулна: 4.1.1. бүх төрлийн сүүн тэжээлтэн тэжээвэр болон зэрлэг амьтан, хэвлээр явагч усны амьтан, шувуу, зөгий, тэдгээрийн үр, хөврөл үр, үржлийн өндөг; 4.1.2. мах, сүү, дайвар бүтээгдэхүүн, өөх, хүнсний өндөг, арьс, шир, яс, ноос, ноолуур, үс, өлөн, эвэр, туурай, шувууны өд, сөд, сарвуу, чив, засаа, залаа, цөс, булчирхай зэрэг амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн; 4.1.3. байгалийн болон таримал дээд, доод ургамал, мод, тэдгээрийн үр, суулгац, хэсэг; 4.1.4. үр тариа, төмс, хүнсний ногоо, өвс, тэжээл, үрлэн кофе, хөнгөн болон хүнсний үйлдвэрт хэрэглэгдэх ургамлын гаралтай бусад түүхий эд, ургамлын хатаадас, цуглуулга, тасалбар, зүсмэл мод, түүний хэсэг, бүх төрлийн жимс, жимсгэнэ, гурил, будаа, элсэн чихэр, амтлагч зэрэг ургамлын гаралтай аливаа зүйлс; 4.1.5. цус болон цусны ийлдэс, сийвэн; 4.1.6. ангийн олзвор; 4.1.7. төрөл бүрийн эмгэг төрүүлэгч хорхой, шавьж, бичил биетний өсгөвөр, биотехнологийн аргаар гарган авсан хувиргасан амьд организм; 4.1.8. амьтны хүүр, сэг, ялгадас, эмгэгт материал; 4.1.9. хөрс, хүлэр, чулуу; 4.1.10. тээврийн хэрэгсэл, чингэлэг, сав, баглаа боодол, чигжээс, зөөлөвч, дэвсгэр, хашлага, хөвөнгийн “хөөвөр”, амьтны тоног хэрэгсэл, уяа татлага.